



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.03.15 № 585

танай _____-ны № _____-т

“ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ
ИНСТИТУТ” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
С.ОЧИР-ЭРДЭНЭ ТАНАА

“Хот төлөвлөлт, судалгааны институт”
ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан, санал дүгнэлтийг
хүргүүлж байна.

Хавсралт: ... хуудастай.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР
М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 334/20125098

Улаанбаатар хот

ХАН - 2022/29/НТ - ИА - ТЦГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд 2018-2020 онд үүссэн, харилцагч байгууллага, хувь хүнээс авах 267,651,811.00 төгрөгийн богино хугацаат авлагын төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 "албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2021 оны 5 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын дарга С.Очир-эрдэнэ, нягтлан бодогч О.Бямбасүрэннарт даалгав.

002041035

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН¹ :

“ЭВИДЕНСЕ АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



С.БАДАМГАРАВ


ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР



З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ОТГОНБАЯР



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХАК-2022/29/НА-СА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он</p>	<p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Эвиденс аудит ХХК-ийн Захирал С.Бадамгарав Утас: 99057121 Цахим хаяг: info@evidenceaudit.mn Аудитор: Б.Пушкин Утас: 95047121 Цахим хаяг: pushkin@evidenceaudit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
4. Аудитын тайлан	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Дотоод хяналт	11
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1 Шилэн дансны мэдээлэл	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Албан шаардлага	13
8.2 Зөвлөмж	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НӨАУГ	Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.03.15 № 652

танай _____-ны № _____-т

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ
ИНСТИТУТ ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
С.ОЧИР-ЭРДЭНЭ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн 267,651.8 мянган төгрөгийн зөрчилд цаашид давтан гаргахгүй байх 1 албан шаардлагыг хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]* М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002030896



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.03.15 № 586
танай _____-ны № _____-т

“ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ
ИНСТИТУТ” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
С.ОЧИР-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд 2018-2020 онуудад үүссэн, харилцагч байгууллага, хувь хүнээс авах 267,651.8 мянган төгрөгийн богино хугацаат авлагыг барагдуулаагүй, 2014 онд үүссэн Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу инженер геологи, газар хөдлөл, бүсчлэлийн зураг төсөл боловсруулах ажлын үлдэгдэл 20 хувийн төлбөр, 2020 онд гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн, зөвлөх үйлчилгээ үзүүлсний төлбөр зэрэг нийт 51,327.0 мянган төгрөгийн өглөг төлөгдөхгүй хугацаа хэтэрсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	402,936,098.99	538,133,859.53
1.1.02	Дансны авлага	749,140,395.98	868,646,324.98
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	15,736,867.06	27,197,277.47
1.1.04	Бусад авлага	129,409.00	702,893.25
1.1.06	Бараа материал	45,268,293.23	36,810,536.51
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,213,211,064.26	1,471,490,891.74
1.2.01	Үндсэн хөрөнгө	288,606,758.37	244,411,601.32
1.2.02	Биет бус хөрөнгө	4,580,066.83	3,139,200.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	293,186,825.20	247,550,801.32
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,506,397,889.46	1,719,041,693.06
2.1.1.01	Дансны өглөг	265,117,000.00	219,631,750.00
2.1.1.03	Татварын өр	0.00	20,822,977.11
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	9,548,607.00	25,971.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	274,665,607.00	240,480,698.11
2.2	Өр төлбөрийн нийт дүн	274,665,607.00	240,480,698.11
2.3.01	Өмч: - төрийн	161,153,013.31	161,153,013.31
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,070,579,269.15	1,317,407,981.64
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	268,078,952.61
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,070,579,269.15	1,049,329,029.03
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,231,732,282.46	1,478,560,994.95
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,506,397,889.46	1,719,041,693.06

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	2,234,043,050.93	3,018,583,060.50
02	Борлуулалтын өртөг	1,443,485,605.97	1,661,886,921.57
03	Нийт ашиг(алдагдал)	790,557,444.96	1,356,696,138.93
05	Хүүгийн орлого	897,535.42	0.00
08	Бусад орлого	440,133.10	113,863.64
08.1	Орлогын дүн	1,337,668.52	113,863.64
09	Борлуулалт, маркетингийн зардал	130,474,270.88	404,410,950.34
10	Ерөнхий ба удирдлагын зардал	583,855,230.48	654,371,690.95
12	Бусад зардал	0.00	18,716,300.00
12.1	Зардлын дүн	714,329,501.36	1,077,498,941.29
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	-428,694.67
17.1	Олз, гарзын дүн	0.00	-428,694.67
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	77,565,612.12	278,882,366.61
19	Орлогын татварын зардал	13,448,489.44	10,803,414.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	64,117,122.68	268,078,952.61
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	64,117,122.68	268,078,952.61

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	/төгрөгөөр/	
		Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	964,708,194.81	1,125,861,208.12
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	41,753,951.66	41,753,951.66
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	64,117,122.68	64,117,122.68
2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	1,070,579,269.15	1,231,732,282.46
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	-21,250,240.12	-21,250,240.12
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	268,078,952.61	268,078,952.61
2021 оны 12 сарын 31-р үлдэгдэл	161,153,013.31	1,317,407,981.64	1,478,560,994.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,885,655,303.00	3,378,995,846.58
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,462,486,545.00	2,582,224,462.58
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,635,895.00	18,284,888.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	615,267,800.00	615,267,800.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	797,265,063.00	163,218,696.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,323,948,807.84	3,185,091,291.37
1.2.1	Ажиллагчдад төлсөн	655,928,617.41	1,022,904,372.56
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	240,036,224.05	340,707,292.22
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	28,221,097.00	58,895,280.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	53,924,660.00	63,855,132.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	20,757,200.00	9,800,000.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	89,753.55	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	353,604,895.37	340,841,611.91
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	517,612.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	970,868,748.46	1,348,087,602.68
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	561,706,495.16	193,904,555.21
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	897,535.42	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	897,535.42	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	242,699,950.00	26,219,500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	242,699,950.00	26,219,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-241,802,414.58	-26,219,500.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	32,487,294.67
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	32,058,600.00
3.2.5	Бусад	0.00	428,694.67
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	-32,487,294.67

4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	319,904,080.58	135,197,760.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83,032,018.41	402,936,098.99
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	402,936,098.99	538,133,859.53

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1.1	Борлуулалтын орлого	1,676,046,355.8	1,944,454,545	2,459,362,564	514,908,019	26.48
1.2	Нийслэлийн төсвөөс	559,334,363.64	559,334,364	559,334,360	- 4	0.00
1	Нийт орлогын дүн	2,235,380,719.4	2,503,788,909	3,018,696,924	514,908,015	20.57
2.1	ББӨ	686,301,012.20	634,460,110	809,074,594	174,614,484	27.52
2.2	Цалин, нэмэгдэл	832,542,502.74	974,642,445	1,127,592,395	152,949,950	15.69
2.3	Хоол,унаа	90,693,200.00	171,360,000	122,080,000	- 49,280,000	-28.76
2.4	НДШ	120,415,399.10	154,710,330	165,952,016	11,241,685	7.27
2.5	Түрээс, ашиглалт	53,924,660.00	65,283,019	63,418,768	- 1,864,250	-2.86
2.6	Албан томилолтын зардал	1,092,000.00	12,144,000	780,000	- 11,364,000	-93.58
2.7	Элэгдлийн зардал	54,221,761.20	78,828,066	71,507,933	- 7,320,133	-9.29
2.8	Түүхий эд материалын зардал	64,780,102.75	65,000,000	93,239,677	28,239,677	43.45
2.9	Зар сурталчилгааны зардал	2,461,181.82	42,200,000	38,479,220	- 3,720,780	-8.82
2.10	Сургалтын зардал	32,565,890.03	12,650,000	13,738,728	1,088,728	8.61
2.11	Эрдэм шинжилгээ	33,928,724.55	29,650,000	27,217,826	- 2,432,174	-8.20
2.12	Шуудан холбооны зардал	11,515,237.09	13,800,000	13,043,423	- 756,577	-5.48
2.13	Шатахууны зардал	13,768,181.78	15,000,000	14,913,636	- 86,364	-0.58
2.14	Засварын зардал	35,089,650.74	16,000,000	19,203,363	3,203,363	20.02
2.15	УЗ-н зардал	12,600,000	29,602,000	23,310,000	- 6,292,000	-21.26
2.16	Банкны шимтгэл			905,140	905,140	
2.17	Бусад зардал			22,064,770	22,064,770	
2.18	Валютын ханшийн бодит бус алдагдал			428,690	428,690	

2	Үйл ажиллагааны зардал	2,045,899,504.0	2,315,329,969	2,626,950,178	311,620,208	13.46
3	Үйл ажиллагааны бус зардал	111,915,603.33	120,080,000	112,864,376	- 7,215,624	-6.01
4	Нийт зардал	2,157,815,107.3	2,435,409,969	2,739,814,553	304,404,584	12.50
5	Татвар төлөхийн өмнөх ашиг	77,565,612.12	68,378,940	278,882,371	210,503,431	307.85
6	Татварын зардал	13,448,489.44	6,837,894	10,803,414	3,965,520	57.99
7	Цэвэр ашиг	64,117,122.68	61,541,046	268,078,957	206,537,911	335.61

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ-ын зорилго нь түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн нийслэлийн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, бүс нутаг, хот тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж хотын удирдлага, хот байгуулалтын салбарын байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг олон улсын жишигт нийцсэн хот төлөвлөлтийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, зураг төслөөр хангахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

1. Хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, Үүнд:
 - 1.1 Газар нутаг хүн амын судалгаа
 - 1.2 Эдийн засаг, хөрөнгө оруулалтын судалгаа
 - 1.3 Нийгэм, соёлын судалгаа
 - 1.4 Зам тээвэр, инженерийн дэд бүтцийн судалгаа
 - 1.5 Байгаль орчин, аюулгүй байдлын судалгаа
 - 1.6 Газар ашиглалт, барилгажилтын судалгаа
 - 1.7 Шаардлагатай бусад судалгаа
2. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, Үүнд:
 - 2.1 Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл
 - 2.2 Бүсийн хөгжлийн төсөл
 - 2.3 Чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө
 - 2.4 Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
 - 2.5 Хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
 - 2.6 Шинэ хороолол, бичил хорооллын төлөвлөгөө
 - 2.7 Барилга байгууламжийн зураг төсөл
 - 2.8 Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
 - 2.9 Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2010 оны 50 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” заалттай нийцэж байна.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 25,200.00 мянган төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7. “цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл

ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"
- Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 147 дугаар тушаал "Журам шинэчлэн батлах тухай"
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө	402,936.1	538,133.9	135,197.8
Авлага	765,006.7	896,546.5	131,539.8
Бараа материал	45,268.3	36,810.5	-8,457.8
Үндсэн хөрөнгө	293,186.8	247,550.8	-45,636.0
Нийт хөрөнгийн дүн	1,506,397.9	1,719,041.7	212,643.8
Өр төлбөрийн дүн	274,665.6	240,480.7	-34,184.9
Богино хугацаат өглөг	274,665.6	240,480.7	-34,184.9
Эздийн өмч	1,231,732.3	1,478,561.0	246,828.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,781,063.5	1,959,522.4	178,458.9

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд банк дахь харилцах дансанд байгаа 538,133.8 мянган төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд ХХОАТ-ын авлага 196.5 мянган төгрөг, НӨАТ-ын авлага 24,215.7 мянган төгрөг, НДШ-ийн авлага 2,784.9 мянган төгрөг байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд үүссэн тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгааны авлага 158,732.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 497,354.8 мянган төгрөгийн, хугацаа хэтэрсэн 267,651.8 мянган төгрөгийн найдваргүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36,810.5 мянган төгрөг болж 8,457.7 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэргийн материалын зардал шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 133,426.6 мянган төгрөгийн ердийн үйл ажиллагааг хангахтай холбоотой бичиг хэргийн материал, болон ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой бусад хангамжийн материалаар нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацаанд шинээр 3,475.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2/630 тоот зөвшөөрлөөр 22,396.0 мянган төгрөгийн 4ш компьютер тоног төхөөрөмж худалдан авсан, тайлант хугацааны элэгдлийн зардлыг тооцоолж бүртгэсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 240,480.7 мянган төгрөг болж 34,184.9 мянган төгрөгөөр буурсан нь гэрээгээр ажил гүйцэтгэгчид өгөх өглөгийг төлж барагдуулсантай холбоотой байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын дарга байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн засаг даргын 2021 оны А/369 дугаар тушаалаар Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,503,788.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,435,410.0 мянган төгрөгөөр, 61,541.0 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 3,018,696.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,739,814.6 мянган төгрөгийн зардал гарган, 268,078.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогыг гүйцэтгэл 3,018,696.9 мянган төгрөг болж төлөвлөснөөс 514,908.01 мянган төгрөг буюу 20.6 хувиар давсан нь аж ахуй нэгж байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,739,814.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 304,404.6 мянган төгрөг буюу 12.5 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Үүнд борлуулалтын өртөг болон цалин түүнтэй адилтгах зардал гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 268,078.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 206,537.9 мянган төгрөгөөр илүү байгаа нь тайлант үеийн үйл ажиллагааны орлого нэмэгдсэн нь нөлөөлж байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эвиденсе аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Пушкин, аудитор Д.Шүрэнцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Эвиденсе аудит ХХК-ийн захирал, ахлах аудитор С.Бадамгарав, НТАГ-ын аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Эвиденсе аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 1/91 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн 1,506,397.8 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 7,531.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 4,612,459.13 мянган төгрөгийн 142 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг ил тод, хугацаанд нь бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

6.1. Завсрын аудитын үр дүн:

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

6.2. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 18,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 37,303.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснээс акт, албан шаардлага 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	18,000.0	1	18,000.0	-	-	-
Албан шаардлага	1	37,303.8	1	37,303.8	-	-	-
Нийт дүн	2	55,303.8	2	55,303.8	-	-	-

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хугацаа хэтрүүлсэн авлага, өглөгийн байдлыг анхааран үзэх шаардлагатай.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 318,978.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 267,651.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 51,327.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

8.1 Албан шаардлага

Тайлант онд 2018-2020 онд үүссэн харилцагч байгууллага, хувь хүнээс авах 267,651.8 мянган төгрөгийн богино хугацаат авлагын төлөлт хийгдээгүй, хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

8.2 Зөвлөмж

1. Өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд Нью урбанизм ХХК-тай холбоотой 2014 онд үүссэн Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу инженер геологи, газар хөдлөл, бүсчлэлийн зураг төсөл боловсруулах ажлын үлдэгдэл 20 хувийн төлбөр болох 43,827.0 мянган төгрөг, иргэн доктор И.Базаррагчаатай холбоотой 2020 онд үүссэн Авторесайклинг парк байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлсний 4,500.0 мянган төгрөг, Топ гео техник ХХК-тай холбоотой 2020 онд үүссэн Авторесайклинг парк байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах шатны инженер геологийн судалгааны ажлын 3,000.0 мянган төгрөг нийт 51,327.0 мянган төгрөгийн өглөг төлөгдөхгүй хугацаа хэтэрсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах" 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж:

Байгууллага болон хувь хүнтэй холбоотой үүссэн ажил гүйцэтгүүлэх гэрээний дагуу төлбөрийг хугацаанд нь хийж, авлага өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллага болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
					Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	Хот төлөвлөлт судалгааны ИНСТИТУТ ОНӨААТҮГ	ХАК-2022/29/НА-СА-ОНА	Санхүүгийн тайланд 267,651.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага төлөгдөөгүй.	Тухайн авлагыг яаралтай төлүүлэх, арга хэмжээ авах	1	267,651.81					1	267,651.81					
2			Санхүүгийн тайланд 51,327 мянган төгрөгийн өглөг төлөгдөөгүй.	Тухайн өглөгийг яаралтай төлөх, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх	1	51,327.00									1	51,327.00	
ДҮН					2	318,978.81					1	267,651.81			1	51,327.00	

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:


“ЭВИДЕНСЕ АУДИТ” ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

БЭЛТГЭСЭН:

ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК-ИЙН

АХЛАХ АУДИТОР



С.БАДАМГАРАВ

Б.ПУШКИН /...../